



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 03 сарын 04 өдөр

Дугаар A/104

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд галт зэвсэг эзэмшигч болон сонирхогч иргэдийн дунд 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Орхон аймгийн Засаг даргын нэрэмжит “Добу мэргэн-2017” Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион явуулах 1500000 төгрөгийн, Австри улсад 2017 оны 03 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд болох Дэлхийн тусгай олимпийн өвлийн наадамд Орхон аймгийг төлөөлж оролцох тамирчин М.Гантөмөр, дасгалжуулагч Д.Одгэрэл нарт 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ